



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ИРГЭНИЙ
ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН
ШИЙДВЭР**

2024 оны 06 сарын 10 өдөр

Дугаар 182/ШШ2024/02664

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН НЭРИЙН ӨМНӨӨС

Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Х.Дашдэчмаа даргалж, тус шүүхийн шүүх хуралдааны танхимд хийсэн шүүх хуралдаанаар,

Хүсэлт гаргагч: Чингэлтэй дүүрэг, 1 дүгээр хороо, Сүхбаатарын талбай-3, өөрийн байранд байрлах, “Монголын хөрөнгийн бирж” ХК /РД:2071096/-ийн хүсэлттэй,

Иргэний эрх зүйн маргаанд хариуцагчаар оролцвол зохих этгээд болох “Бинсэ” ХК /РД:2004917/, түүнийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд Батбаатарын Батзаяа /РД:ШГ84042570/-г эрэн сурвалжлуулахыг хүссэн иргэний хэргийг хянан хэлэлцэв.

Шүүх хуралдаанд: Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга Б.Түмэнхүслэн оролцов.

ТОДОРХОЙЛОХ нь:

“Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Цогтбаяр шүүхэд гаргасан хүсэлтдээ: “...“Бинсэ” ХК нь “Монголын хөрөнгийн бирж” ХК-иар 1993.04.17-ны өдөр Засгийн газрын өмч хувьчлалын тогтоолоор хувьчлагдсан. “Баянхайрхан” ХК нэрээр “Монголын хөрөнгийн бирж” ХК-иар дамжуулан үнэт цаасны арилжаагаа 1993.06.07-ны өдөр Бүртгэлийн гэрээ байгуулан гүйцэтгүүлж эхэлсэн одоог хүртэл тус биржид бүртгэлтэй хэвээр байна.

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.3-т заасны дагуу “Монголын хөрөнгийн бирж” ХК нь үйлчилгээний хөлс болон урамшууллыг тогтоох эрхтэй байгууллага бөгөөд үнэт цаасны бүртгэлийн журам батлан дагаж мөрдүүлж, үйлчилгээний хөлсөө тогтоосон. Тус журмын 21 дүгээр зүйлийн 21.7-д зааснаар жилийн үйлчилгээний хөлсийг тухайн оны 01 дүгээр улиралд багтаан биржийн дансанд төлөхөөр заасан байдаг.

Гэвч “Бинсэ” ХК нь төлбөл зохих төлбөрөө цаг тухайд нь төлөх үүргээ биелүүлэлгүй өнөөдрийг хүрсэн тул шүүхээр шийдвэрлүүлэхээс өөр аргагүй байдалд хүрч оршин байрлах хаягийн дагуу Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргасан боловч тус шүүхийн 2024.04.15-ны өдрийн 102/Ш32024/07780 дугаартай шүүгчийн захирамжаар хаяг тодорхойгүй үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.

Иймд “Бинсэ” ХК, түүнийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд Б.Батзаяаг эрэн сурвалжилж өгнө үү...” гэжээ.

240097 9

- Хүсэлт гаргагч нь энэхүү шаардлагатай холбогдуулан улсын тэмдэгтийн хураамжид 2024.05.08-ны өдөр 70,200 төгрөг тушаасан баримт /хх-ийн 3 х/,
- Улсын бүртгэлийн 9007001016 дугаартай хуулийн этгээдийн гэрчилгээ /хх-ийн 4 х/,
 - 2024.01.02-ны өдрийн 01 дугаартай Монголын Хөрөнгийн бирж хувьцаат компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол /хх-ийн 5 х/,
 - 2006.10.26-ны өдрийн ТЗ/305-01 дугаартай Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ /хх-ийн 6-7 х/,
 - “Монголын хөрөнгийн бирж” нээлттэй хувьцаат компанийн дүрэм /хх-ийн 8-17 х/,
 - 1993.04.17-ны өдрийн 18 дугаартай Монгол Улсын Засгийн газрын өмч хувьчлалын комиссын тогтоол /хх-ийн 18-19 х/,
 - Улсын бүртгэлийн 9011173039 дугаар бүхий хуулийн этгээдийн гэрчилгээ /хх-ийн 20 х/,
 - 2014.10.03-ны өдрийн 153 дугаартай Монголын хөрөнгийн биржийн гүйцэтгэх захирлын “Үнэт цаас бүртгэлд өөрчлөлт оруулах тухай” тушаал /хх-ийн 21 х/,
 - 2014.07.07-ны өдрийн 269 дугаартай Санхүүгийн зохицуулах хорооны “Баянхайрхан” ХК-д “Бинсэ” ХХК-ийг нэгтгэх, компанийн оноосон нэрийг өөрчлөх тухай” тогтоол /хх-ийн 22 х/,
 - Үнэт цаасны бүртгэлийн журам /хх-ийн 23-29 х/,
 - “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолууд, тэдгээрийн хавсралт /хх-ийн 30-40 х/,
 - “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн нэхэмжлэх /хх-ийн 41 х/,
 - Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2024.04.15-ны өдрийн 102/ШЗ2024/07780 дугаартай “Хэргийг хэрэгсэхгүй болгох тухай” захирамж /хх-ийн 42 х/,
 - 2024.05.09-ний өдрийн 01/360 тоот Х.Оюунсанаад олгосон итгэмжлэл /хх-ийн 43 х/ зэрэг баримтуудыг хавсарган ирүүлсэн байна.

ҮНДЭСЛЭХ нь:

Шүүхээс хүсэлтийг хангаж шийдвэрлэх үндэслэлтэй гэж үзлээ.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 155 дугаар зүйлийн 155.1-д “Иргэний эрх зүйн маргаанд хариуцагчаар оролцвол зохих этгээд оршин суугаа газар нь мэдэгдэхгүй бол түүнийг эрэн сурвалжлуулах тухай хүсэлтийг шүүхэд гаргаж болно” гэж заасан.

Иргэний эрх зүйн маргаанд хариуцагчаар оролцвол зохих этгээд болох “Бинсэ” ХК, түүнийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд Б.Батзаяагийн оршин /байрлах/ суугаа газар нь мэдэгдэхгүй байгаа тул түүнийг эрэн сурвалжлуулахаар “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Цогтбаяр шүүхэд хүсэлт гаргажээ.

Хэрэгт авагдсан болон шүүх хуралдаанаар хэлэлцэгдсэн хуулийн этгээд гэрчилгээнд иргэний эрх зүйн маргаанд хариуцагчаар оролцвол зохих этгээд болох “Бинсэ” ХК, түүнийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд Б.Батзаяагийн оршин /байрлах/ суух хаягийг Баянгол дүүрэг, 4-р хороо, 2-р хороолол, Энхтайваны өргөн чөлөө гудамж, 018 дугаар байр, 14 тоот гэж тодорхойлсны дагуу “Монголын хөрөнгийн бирж” ХК нь үйлчилгээний төлбөрт 4,000,000 төгрөг гаргуулахаар Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд хандсан байна.

Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2024.04.15-ны өдрийн 102/ШЗ2024/07780 дугаартай шүүгчийн захирамжаар “Бинсэ” ХК, түүнийг

итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд Б.Батзаяа нь нэхэмжлэлд дурдсан хаягт "...бүртгэлтэй боловч оршин /байрладаггүй/ суудаггүй..." гэх хорооны Засаг даргын тодорхойлолтыг үндэслэн хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ. /хх-ийн 42 х/

"Бинсэ" ХК нь гишүүн компанийн үйлчилгээний хураамж төлөх үүргээ биелүүлээгүй талаарх баримт хэрэгт авагдсан, энэхүү үйлчилгээний хураамжтай холбоотой нэхэмжлэл гаргах "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн шаардлагад хариуцагч болох үндэслэлтэй байна. /хх-ийн 41 х/

"Бинсэ" ХК, түүнийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд Б.Батзаяа нь дээрх хаягт "...бүртгэлтэй боловч оршин /байрладаггүй/ суудаггүй..." болох нь Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2024.04.15-ны өдрийн 102/ШЗ2024/07780 дугаартай "Хэргийг хэрэгсэхгүй болгох тухай" шүүгчийн захирамж, "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Цогтбаярын шүүхэд ирүүлсэн хүсэлтээр тус тус тогтоогдлоо.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 155 дугаар зүйлийн 155.3-д "Хүсэлтэд хариуцагчаар оролцвол зохих этгээдийг эрэн сурвалжлуулах үндэслэлийг тодорхойлж, түүний оршин байгаа газрыг олж тогтооход ач холбогдол бүхий бичиг баримтыг боломжтой бол хавсаргана. Шүүх хүсэлтийг хүлээн авч эрэн сурвалжлах тухай шийдвэр гаргана", 155.4-т "Хариуцагчаар оролцвол зохих этгээдийг эрэн сурвалжлах, түүний оршин /байрлах/ суугаа газрыг тогтоох ажиллагааг шүүхийн шийдвэрийн дагуу цагдаагийн байгууллага гүйцэтгэнэ" гэж тус тус заасан.

Иймд "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн хүсэлтийг хүлээн авч иргэний эрх зүйн маргаанд хариуцагчаар оролцвол зохих этгээд болох "Бинсэ" ХК, түүнийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд Б.Батзаяагийн оршин /байрлах/ суугаа газрыг тогтоох ажиллагааг түүний сүүлд оршин /байрлаж/ сууж байсан харьяа дүүргийн Цагдаагийн байгууллагад даалгах нь зүйтэй гэж үзлээ.

Хүсэлт гаргагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч шүүх хуралдааныг өөрийг нь оролцуулахгүйгээр хийж өгөх хүсэлтийг ирүүлсэн байх тул Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 100 дугаар зүйлийн 100.1-д заасны дагуу түүнийг оролцуулахгүйгээр хэргийг хянан шийдвэрлэсэн болно.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1, Улсын тэмдэгтийн хураамжийн хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2-т зааснаар хүсэлт гаргагчийн улсын тэмдэгтийн хураамжид төлсөн 70,200 төгрөгийг улсын орлогод хэвээр үлдээж шийдвэрлэв.

Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 115 дугаар зүйлийн 115.2.1, 133 дугаар зүйлийн 133.1.9-д заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 155 дугаар зүйлийн 155.3-т зааснаар иргэний эрх зүйн маргаанд хариуцагчаар оролцвол зохих этгээд болох "Бинсэ" ХК /РД:2004917/, түүнийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд Батбаатарын Батзаяа /РД:ШГ84042570/-г тус тус эрэн сурвалжилсугай.

2.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 155 дугаар зүйлийн 155.4-т зааснаар "Бинсэ" ХК, түүнийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд Б.Батзаяаг эрэн сурвалжлах, оршин /байрлах/ суугаа газрыг тогтоох ажиллагааг

түүний сүүлд оршин /байрлаж/ сууж байсан харьяа дүүргийн Цагдаагийн байгууллага болох Баянгол дүүргийн Цагдаагийн газарт даалгасугай.

3.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1, Улсын тэмдэгтийн хураамжийн хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2-т зааснаар хүсэлт гаргагчийн улсын тэмдэгтийн хураамжид төлсөн 70,200 төгрөгийг улсын төсөвт хэвээр үлдээсүгэй.

4.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.2, 120 дугаар зүйлийн 120.2-т тус тус зааснаар шийдвэр танилцуулан сонсгомгоц хүчинтэй болох бөгөөд зохигч шийдвэрийг гардан авсан өдрөөс хойш 14 хоногийн дотор Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхэд давж заалдах гомдол гаргаж болохыг дурдсугай.

ДАРГАЛАГЧ ШҮҮГЧ



Х.ДАШДЭЧМАА